

СУЛ ХАРАА

УДИРТГАЛ

Шүүмжлэгчид:

Жилл Кийф

Австралийн Нүдний Судалгааны Төв, Мелбурн хот, Австрали улс

Пириндхавей Говендер

КваЗулу Натал Их Сургууль, Дурбан хот, Өмнөд Африк

Редакторууд

Брайн Холден Харааны Интститут, Нийгмийн
Эрүүл мэндийн Хэлтэс

Брайн Холден Харааны Институт Сан нь Брайн Холден Харааны
Институтын Нийгмийн Эрүүл мэндийн Хэлтэс юм

Сургалтын зорилго:

Дараах сэдвүүдийг тоймлоно:

- Сул харааны тодорхойлолт
- Сул харааны нөлөө
- Сул харааны дэлхий даяарх тархалт
- Сул харааны тусламж үйлчилгээ гэж юу вэ
- Сул харааны хөтөлбөрт юу багтдаг вэ
- Сул харааны хөтөлбөрийн олон түвшнүүд гэж юу вэ
- Сул харааны хөтөлбөрийг хэрхэн үнэлэх вэ
- Сул харааны сэтгэц-нийгэмд үзүүлэх нөлөө

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) тодорхойлолт

Сайн нүдэндээ эмчилгээ хийлгэж болон/эсвэл хугарлын гажгийг стандартаар зассаны дараа ч харааны үйл ажиллагаа нь алдагдсан хүнийг сул хараатай гэнэ:

- Харааны чадал 6/18-аас 3/60 хүртэлх хэмжээнээс бага байх (6/18-аас гэрэл мэдрэх хүртэлх хэмжээнээс бага болгож зассан)
- Харааны талбай фиксагийн цэгээс $<10^\circ$ байх

Үйл ажиллагааны сул харааны тодорхойлолт

- 3/60-аас бага харааны чадалтай сул харааны хөтөлбөрт хамрагдаж буй хүмүүсийг багтаана
- Тодорхойлолт

Эмчилгээ хийх болон/эсвэл хугарлын гажгийг стандартаар зассаны дараа харааны үйл ажиллагаа нь алдагдаж, харааны чадал 6/18-аас гэрэл мэдрэх хүртэлх бөгөөд харааны талбай фиксагийн цэгээс $<10^\circ$

- Үйлчлүүлэгч ажил төлөвлөх эсвэл гүйцэтгэхийн тулд хараагаа ашигладаг эсвэл ашиглах бүрэн чадамжтай

Сул харааны нөлөө

- Сул хараа нь дараах салбаруудад нөлөөлнө:
 - Боловсрол, ажил болон амралт
 - Нийгмийн болон хэрэглэгчийн харилцаа
 - Хөдөлгөөн
 - Хараа алдалтын үед үүсэх сэтгэлзүйн хариу урвал
 - Гэрийн болон хувийн арчилгаа

Сул харааны нөлөө

- Дараах зүйлсэд нөлөөлж болно
 - Хүүхдийн хэвийн хөгжил болон боловсрол
 - Насанд хүрэгчдийн өдөр тутмын амьдрал, ажил болон амралтын бүх салбарууд
- Хараа алдагдлын хэмжээ нь үйл ажиллагаа болон хамтын оролцоонд шаардлагатай харааны хязгаарыг тодорхойлохгүй

Дэлхий нийтийн тархалт

- 124 сая хүн сул хараатай
 - 65 сая хүн эргэшгүй сул хараатай бөгөөд сул харааны тусламж үйлчилгээ авах шаардлагатай байдаг
- Ихэнх сул хараатай хүмүүс ахимаг настай байдаг бөгөөд нийт хүн амын насжилтын улмаас дараагийн 20-30 жилд тоон үзүүлэлтүүд 2 дахин нэмэгдэх хандлагатай байна
- Хүүхдийн тоо бага боловч сул хараатай амьдралын жилүүдийн дарамт ачаалал ач холбогдолтой байдаг

Дэлхий нийтийн тархалт

- Тархалт Энэтхэг улсад 10%-аас хамгийн өндөр хөгжилтэй орнуудад 1%-с бага байх хүртэл хэлбэлздэгийг судалгаануудаас харж болно
- Дэлхий даяар 1.5 сая сохор хүүхдүүд байна
 - Азид 1 сая
 - Африкд 300,000

Дэлхий нийтийн тархалт

- Жил бүр $\frac{1}{2}$ сая хүүхэд сохролд өртдөг
 - 60% нь хүүхэд насандаа энддэг
- Хүүхдүүдийн дундах сул харааны тархалт сохролын тархалтаас 3 дахин их байдаг
 - Сургууль болон бүртгэлүүд дээр хийсэн судалгаануудаас тооцоог үндэслэн гаргасан

Дэлхий нийтийн тархалт

- ДЭМБ Хүүхдийн Сохролоос Сэргийлэх (ДЭМБ/PVL/00.77) тайландаа хүүхдийн сохролын тархалтыг тодорхойлохдоо
 - Өндөр орлоготой бүс нутгуудад мянган хүүхдийн 0.4-т
 - Дунд орлоготой бүс нутгуудад мянган хүүхдийн 0.7-д
 - Бага орлоготой бүс нутгуудад мянган хүүхдийн 0.9-т

Сул харааны тусламж үйлчилгээг хүргэх аргууд

- Хүмүүсийн сул харааны тусламж үйлчилгээний шаардлагыг тогтоох зорилгоор асуумж авч хийсэн судалгааны үр дүнд
 - Сул хараатай зарим хүмүүст сул харааны тусламж үйлчилгээ шаардлагагүй байдаг
 - Тусламж үйлчилгээ хэрэгтэй хүмүүст тусламжийн хэлбэр болон хэмжээнээс хамаарч шаардлага олон янз байдаг

Сул харааны тусламж үйлчилгээг хүргэх аргууд

- Австралийн Нүдний Судалгааны Төвөөс хийсэн судалгаагаар:
 - Сул харааны тусламж үйлчилгээний шаардлагыг ганц харааны чадлаар тогтоож болохгүй
 - <6/60 харааны чадалтай хүмүүсийн 10% ямар нэгэн хүндрэлгүй байдаг ба сул хараатай хүмүүсийн бэрхшээл нь үйл ажиллагааны төрөл бүрээс хамаарч өөр өөр байдаг гэсэн дүгнэлтүүд гарсан байдаг

Сул харааны тусламж үйлчилгээг хүргэх аргууд

- Австралийн Нүдний Судалгааны Төвөөс хийсэн судалгаагаар:
 - Тодорхой цаг хугацааны цэгт сул хараатай хүмүүсийн 70%-80% нь сул харааны тусламж үйлчилгээнээс үр өгөөж авах боломжтой гэсэн тооцоолол гаргасан

Сул харааны тусламж үйлчилгээний үндэсний төлөвлөлтөнд ямар мэдээллийн санг ашигласан бэ?

- Тусламж үйлчилгээний тоо болон хуваарилалтыг дараах зүйлс дээр үндэслэн тооцоолж болно:
 - Сул харааны тархалт
 - Сул хараатай хүмүүсийн тусламж үйлчилгээний шаардлага

Сул харааны тусламж үйлчилгээний үндэсний төлөвлөлтөнд ямар мэдээллийн санг ашигласан бэ?

- Хүн амд суурилсан тархалтын судалгаагаар тодорхой хүн амын дундах хараа алдагдлын тархалт болон шалтгааны талаар мэдээлэл үүсгэдэг
- Хүн амд суурилсан судалгаа хийгдээгүй бол газар зүй эсвэл эдийн засгийн байдал ижил орнуудад хийсэн судалгаагаар тооцооллыг гаргаж болно (Кийф нар)

Сул харааны тусламж үйлчилгээний үндэсний төлөвлөлтөнд ямар мэдээллийн санг ашигласан бэ?

- Хүүхдүүдийн дундах сул хараа болон сохролын тархалтыг тухайн улс дахь хүүхдийн нас баралтаар тооцоолж болно
 - Хүүхдийн Сохролоос Сэргийлэх ДЭМБ/PVL/00.77 тайланд үндэслэсэн
- Сул хараанд хүргэж буй насжилтын шалтгаант нүдний эмгэгүүдийн байдлыг тодорхой хүн ам эсвэл улс орны дундаж наслалтаар тооцоолж болно

Тусламж үйлчилгээнүүдийн нэгдэл

Сул харааны тусламж үйлчилгээг олон тогтолцоонуудын бүрэлдэхүүн:

- Нүд ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Нүдний тусламж үйлчилгээ, боловсролын болон сэргээн засах тусламж үйлчилгээ
- Төвд суурилсан, хамрах хүрээ

Сул харааны тусламж үйлчилгээнүүдийг нэгтгэх аргууд

- Хараагүйчүүдийн сургуулийн хүүхдүүдийг хамруулан хэрэгцээт бүх хүмүүст сул харааны тусламж үйлчилгээг хөгжүүлж, хүртээмжтэй болгох
- Сул харааны тодорхой төхөөрөмжийг бүс нутагтаа үйлдвэрлэх эсвэл зардлаа хэмнэх зорилгоор олноор авах
- Сохролоос сэргийлэх үндэсний хөтөлбөрүүд ба/эсвэл сэргээн засах үйлчилгээнүүдэд цогц сул харааны үйлчилгээг оруулах

Сул харааны тусламж үйлчилгээ

- Нүдний тусламж үйлчилгээнд сул харааны тусламжийг хэд хэдэн өөр түвшинд хүргэдэг бөгөөд эдгээр түвшнүүдэд хувь хүмүүс тодорхой үүрэг гүйцэтгэн ажилдаг. Сул харааны тусламж үйлчилгээ хүргэдэг түвшинг:
 - Анхан
 - Хоёрдогч
 - Гуравдагч

Анхан шатны сул харааны тусламж үйлчилгээ

Гол үүрэг гүйцэтгэгчид: багш нар, нийгэмд суурилсан сэргээн засах ажилтнууд болон нүдний анхдагч тусламж үйлчилгээ үзүүлэгч эсвэл эрүүл мэндийн анхдагч тусламж үйлчилгээ үзүүлэгчид

Үйл ажиллагаа	Ажилтан	Нөөц
Мэдээлэл хүргэх Скрининг	Нүдний анхдагч тусламж үйлчилгээ үзүүлэгч/эрүүл мэндийн анхдагч тусламж үйлчилгээ үзүүлэгчид	Тохирсон харааны чадал шалгах тест (нүхэн шалгагчтай)
Илгээх	Нийгэмд суурилсан нөхөн сэргээх ажилтнууд	Оптикийн бус төхөөрөмжүүдийн загвар ба заавар
Ерөнхий нөхөн сэргээлт	Багш нар	ДЭМБ-ын сул харааны иж бүрдэл

Анхан шатны сул харааны тусламж үйлчилгээний үүрэг

- Боловсрол
- Илрүүлэлт
- Цаашид үнэлэх эсвэл эмчлэх зорилгоор тохиромжтой түвшин рүү илгээх
- Зарим тохиолдолд: энгийн сул харааны төхөөрөмжийг өгөх, хүрээлэн буй орчныг өөрчлөх талаар зөвлөгөө өгөх, гэх мэт

Хоёрдогч сул харааны тусламж үйлчилгээ

Үйл ажиллагаа	Ажилтан	Нөөц
<ul style="list-style-type: none">• Хугарлын гажиг болон сул харааны шийдвэрлэх скрининг• Анхдагч сул харааны тусламж үйлчилгээ хүргэх явцыг хянаж, зөвлөгөө өгөх• Оптикийн болон оптикийн бус туслах төхөөрөмжүүдийг өгөх• Ерөнхий нөхөн сэргээлт	Оптометристууд	ДЭМБ-ийн Сул Харааны Иж бүрдэл Хугарлын гажгийг тодорхойлох багаж төхөөрөмж

Гуравдагч сул харааны тусламж үйлчилгээ

Үйл ажиллагаа	Ажилтан	Нөөц
<ul style="list-style-type: none">• Зориулалтын сул харааны тусламж үйлчилгээ• Иж бүрэн оношлогоо• Сул харааны багаж төхөөрөмжийг зөвлөж өгөх• Доод түвшний мэргэжилтнүүдийг сургаж, зөвлөгөө өгөх• Ухуулга сурталчилгаа болон өөрчлөлт сайжруулалтад зориулан судалгаа хийх	Оптометристууд (бүрэн мэргэшсэн)	Сул харааны бүрэн иж бүрдэл

Сул харааны сэтгэцийн холбоо хамаарал

- Сохрол эсвэл хараа муудалт үүссэн нас ач холбогдолтой нөлөө үзүүлдэг:
 - Төрөлхийн сохор эсвэл хараа алдагдалтай хүмүүс хараа алдагдлаа хялбар хүлээн зөвшөөрдөг гэх ойлголтыг бүү дэлгэрүүл

Сул харааны сэтгэцийн холбоо хамаарал

- Хараа алдагдал
 - Төрөлхийн
 - Олдмол
- Хараатай хүмүүсийн ертөнцөд сохролд дасан зохицон гэдэг нь тохиолдол бүрт өөр өөр
- Дасан зохицол дараах зүйлсээс шалтгаална: шалтгаан, даамжралын хурд, тогтвортой байдал болон хараа алдагдлын хэмжээ хязгаар

Сул харааны сэтгэцийн холбоо хамаарал

- Хараа алдагдал түргэн – гэмтэл, эсвэл удаан – тахиан сохор, явцтай байж болно
- Төрөлхийн хараа алдагдлын үед хувь хүн нөхцөл байдлыг хүчээр хүлээн зөвшөөрч болно
- Гэнэтийн байдал, гэмтэл ба сэтгэл гутралаас болж олдмол хараа алдагдлын үед дасан зохицох тодорхой хугацаа хэрэгтэй байдаг

Хараа алдагдлын нөлөө

- Дараах нийгмийн үүрэг гүйцэтгэхэд дундаас хүнд зэргийн хязгаарлалт үүснэ:
 - Ажил
 - Сургууль
 - Амралтын үйл ажиллагаа
 - Гэр бүлийн амьдрал
 - Нөхөрлөл
- Хөдөлмөрийн чадваргүй байдалтай тэмцэхэд гэр бүлийн гишүүд болон найзуудын хандлага чухал үүрэг гүйцэтгэнэ

Хэвшсэн хандлагууд

- Эцэг эх, мэргэжилтнүүд тэр тусмаа үйлчлүүлэгчдийн өөртөө итгэх итгэлд сөрөг нөлөө үүсдэг
- Төрөлхийн харааны бэрхшээлтэй зарим хүүхдүүд ямар ч асуултгүйгээр сөрөг хандлагуудыг хүлээн зөвшөөрдөг болсон байдаг

Хэвшсэн хандлагууд

- Буруу хэвшсэн ойлголтууд:
 - Бусдаас доогуур, хэнд ч хэрэггүй
 - Өрөвдмөөр
 - Ялангуяа дотно харилцаанаас айх, зайлсхийх
 - Сэтгэл хөдлөлийн болон бэлгийн амьдралын хувьд дасан зохицоогүй
 - Нүгэл, садар самуун болон хорон санааныхаа төлөө төлөөс төлж байгаа
 - Ажилгүй
 - Тайван эсвэл амар байдлаар ойртоход бэрх

Хараа алдагдлын нөлөө

- Хараа алдалт нь хувь хүний амьдралын 3 томоохон хэсэгт нөлөөлдөг:
 - Үйл ажиллагааны нөлөө
 - Нийгмийн нөлөө
 - Сэтгэцийн нөлөө

Үйл ажиллагааны нөлөө

- Эмгэгийн байрлал үйл ажиллагааны түвшинг тодорхойлдог

Жишээ нь

- Харааны талбайн хагасаас их хэмжээнд хараа алдсан бол чөлөөт хөдөлгөөнд нөлөөлнө
- Харааны талбайн баруун хэсэг алдагдвал унших үйлд нөлөөлнө
- Төвийн хараа алдагдсан бол сурлагад нөлөөлнө
- Захын хараанд нөлөөлсөн бол биемахбодийн үйл ажиллагаанд хүндрэл үүснэ
- 2 нүдний харааны чадал ялгаатай бол хөдөлгөөнд чухал үүрэг гүйцэтгэх гүний мэдрэхүүнд нөлөөлнө

Нийгмийн нөлөө

- Зан чанар нь бусдын хандлагад нөлөөлөх ч хувь хүний өөртөө итгэлтэй байдал болон өөрийгөө дүгнэж цэнэх байдлын тусгал болдог
- Харааны бэрхшээлтэй хүн өөрийн талаар, сохролын талаар болон өөрт хандсан бусдын хандлагын талаар юу мэдэрч байгаа нь өөртөө итгэлтэй байдалд шууд нөлөөлдөг
 - Дасан зохицох зан чанар болон ялан дийлэх ур чадвар шаардлагатай

Боловсроогүй болон хувиа хичээсэн зан авир

- Харааны бэрхшээлтэй хүүхдүүд болон залуучууд нийгмийн хувьд илүү боловсроогүй байдаг
- Харааны бэрхшээлгүй үе тэнгийнхнээ бодвол илүү хувиа хичээсэн байдаг

Шалтгаанууд:

- Нийгэмших, зөв зан авирт дагалдан суралцах боломж бага
- Олон зүйлд дасан зохицох болон ялан дийлэх асуудлуудад санаа зовдог
- Бүрэг ичимхий

Тусгаарлалт болон асуудлаас зугтах

- Шалтгаанууд:
- Харилцан ярих хамтрагчаа сонгож чадахгүй
- Бусдыг харилцан яриаг эхлүүлэхийг хүлээдэг
- Бүлэг дотор тэдэн рүү чиглэсэн тайлбар гаргахад ярианд оролцож чадахгүй
- Нийгмийн харилцаанд ярианы бус дохио зангааг ажиглахгүй
- Хараа сайтай хүмүүс харааны бэрхшээлтэй хүнд ойртоход итгэлтэй биш байдаг

Идэвхигүй байдал ба хамаарал

- Харааны бэрхшээлтэй хүн илүү идэвхгүй, өөртөө итгэлгүй байдаг

Шалтгаанууд:

- Яаралтай үед зөв хариу урвалаар хурдан хариу өгөхөд хүндрэлтэй
- Шийдвэрийг тэдэнтэй зөвлөлгүйгээр тэдний өмнөөс гаргадаг
- Тэдэнд сонголт хийх чадвараа хөгжүүлэх болон дадлагажуулах боломж хязгаарлагдмал
- Хэн нэгний унагаасан зүйлийг авч өгөх гэх мэт нийгмийн найрсаг занг ажиглаж, хүлээн авах боломжгүй

Нийгмийн буруу үлгэр жишээ

- Харааны бэрхшээлтэй хүнд тогтсон үлгэр жишээг дагахад хүндрэлтэй байдаг
- Ажиглалт хийх тоо, хязгаар болон төрөл зүйл хязгаарлагдмал
- Нийгмийн харилцаанд оролцох боломж хязгаарлагдмал
- Тэдний зарим ааш авир нийгмийн хувьд хүлээн зөвшөөрөгдөх боломжгүйг мэддэггүй

Сэтгэцийн нөлөө

- **Үгүйсгэл** – бодит байдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах
- **Уур хилэн** – тодорхой нөхцөл, хүн эсвэл Бурханд уурлах
- **Айдас** – үлдэгдэл хараа, ажил эсвэл амьдралаа алдахаас айх
- **Уй гашуу** – хараа алдагдад болон нөхцөл байдлаас болж гуньж гашуудах

Сэтгэцийн нөлөө

- **Сэтгэл гутрал** – хараа алдагдал, нийгэмд оролцохгүй байдлаасаа болж сэтгэл гутарч, амьдралд сонирхол буурах
- **Тусгаарлалт** – хэн нэгэнд хамааралтай байхаасаа илүү тусгаарлагдмал байхыг илүүд үзэх (аялах гэх мэт)
- **Асуудлаас зугтах** – нийгмийн бүх харилцаанд оролцохгүй
- **Өөртөө итгэх итгэл бага** – сэтгэл санаа доогуур, өөрийн хэм хэмжээгээ мэдэхийг хүсэхгүй байх

Хараа алдагдлаас болж үүсэх үндсэн алдагдлууд

- Хараа алдагдлаас болж хувь хүнд 20 үндсэн алдагдал учирдаг (Berthold Lowenfeld)

Сэтгэцийн аюулгүй байдалд үүсэх үндсэн алдагдал

Биемахбодийн бүрэн бүтэн байдлын алдагдал

- Би хэвийн биш... Би тахир дутуу... Би бүрэн бүтэн хүн биш... гэх мэт

Үлдсэн мэдрэхүйнүүдэд итгэлээ алдах

- Би юу сонссондоо итгэж чадахгүй байна... Миний хүрч байгаа зүйл юу гэдгийг би мэдэхгүй байна...

Орчин тойронтойгоо бодит байдлын холбоогоо алдах

- Энэ дэлхий бодит биш, миний мэддэг байсан зүйлс, танидаг байсан хүмүүс, мэддэг байсан газрууд оршин тогтнохоо больсон юм шиг санагдаж байна

Сэтгэцийн аюулгүй байдалд үүсэх үндсэн алдагдал

Харааны арын талбайн алдагдал

- Би эргэн тойрныхоо байгалийн үзэмжийг харж чадахаа больсон...

Гэрэл мэдрэхүй алдагдах

- Би үргэлж харанхуйгаас айдаг байсан...

Суурь ух чадваруудын алдагдал

Чөлөөт хөдөлгөөний алдагдал

- Би нэг газраас нөгөө рүү очиж чадахгүй

Өдөр тутмын амьдралын техникийн алдагдал

- Би үсээ самнаж чадахгүй... Би хоолоо хийж чадахгүй... ГЭХ МЭТ

Харилцааны алдагдал

Бичгийн харилцааны хялбар байдал алдагдах

- Би ном уншиж чадахгүй... Би захиа уншиж чадахгүй...

Яриан харилцааны хялбар байдал алдагдах

- Би хүнтэй ярилцаж байхдаа түүний дохои зангааг харж чадахгүй; түүний нүүрний хувирлыг харж чадахгүй...

Мэдээллийн өсөлт дэвшлийн алдагдал

- Би орчин үетэйгээ хөл нийлүүлж чадахгүй...

Талархал алдагдах

Сэтгэлд таатай зүйлсийг харж хүлээн авах алдагдал

- Би хүүхдүүдийнхээ тоглохыг харж чадахгүй, би эхнэрийнхээ надад хоол бэлдэж байгааг харж чадахгүй... гэх мэт

Гоё сайхан зүйлсийг харж хүлээн авах алдагдал

- Гайхалтай нар жаргалт, Ренвуагийн зургийг би харж чадахгүй....

Мэргэжил болон санхүүгийн байдалтай холбоотой алдагдлууд

Зугаа цэнгэлийн алдагдал

- Би теннис тоглож чадахгүй. Би тамга лацны цуглуулгаа зогсоох хэрэгтэй боллоо...

Мэргэжил карьерын зорилго, ажлын боломжийн алдагдал

- Би ажлаа солих шаардлагатай боллоо, би мэргэшиж байсан ажлаа хийх боломжгүй боллоо.

Санхүүгийн аюулгүй байдлын алдагдал

- Хэн байрны түрээс, миний гэр бүлийн хоол хүнсний зардлыг төлөх вэ...

Бүхэл хувь хүний зан чанарт үүсэх алдагдлууд

Хувийн хараат бус байдлын алдагдал

- Би бол “хэнд ч хэрэггүй сохор хүн”, би ямар нэг зүйлс хийхийн тулд үргэлж бусдаас хамааралтай байдаг

Нийгмийн нийцэл тохирооны алдагдал

- Сохор хүмүүс бол нийгмийн цөөнх... Хараатай хүмүүс надаас айдаг...

Хувийн нуугдмал байдлын алдагдал

- Надад хувийн амьдрал байхгүй... Би таяг хэрэглэж байхдаа хүн болгоныг над руу харж гэж хэлж байгаа мэт санагддаг...

Бүхэл хувь хүний зан чанарт үүсэх алдагдлууд

Өөртөө итгэлтэй байдлын алдагдал

- Би сайн байхаа больсон... Би байж болох хүний хамгийн муу жишээ...

Хувь хүний зохион байгуулалтын алдагдал

- Сохрол нь хувь хүний зан чанарын тэнцвэртэй байдлыг алдагдуулах, доошлуулах, өөрчлөх чадалтай

Зөвлөгөө

- Энэ нь зөвлөгч үйлчлүүлэгчийн асуудлыг шийдэхэд туслалцаа үзүүлдэг туслах үйл явц юм
- Зөвлөгч үйлчлүүлэгчид илүү үр дүнтэй амьдралд хүрэхэд тусладаг
- Үйлчлүүлэгчид тусламж хэрэгтэй байгаа
 - Өөрийн асуудлаа шийдвэрлэхэд туслагчаас зөвлөмж, дэмжлэг хүсч байдаг

Сайн зөвлөгчийн шинжүүд

- Өөрийгөө сайн мэддэг
- Хувь хүний харагдах байдал
- Харилцаа тогтоох чадвар
- Мэдээлэл цуглуулах чадвар
- Харилцах чадвар
- Шүүмжилдэггүй
- Өөрийгөө бусдын оронд тавьж, зовлонг ойлгох чадвар

Сайн зөвлөгчийн шинжүүд

- Дарамтыг арилгах чадвар
- Тодорхой сэдвийн талаар мэдлэгтэй байх
- Нууц хамгаалах
- Дулаан мэдрэмж төрүүлэх
- Үнэнч байдал
- Хүндлэл
- Бодитой байх

Харааны бэрхшээлтэй хүнд зөвлөгөө өгч, чиглүүлэхийн ач холбогдол

- Эцсийн зорилго нь бусдаас хамааралтай байх түвшинг бууруулах болон тэднийг хэвийн амьдралд хамгийн ойр аваачихад оршино

Зөвлөгөөний чухал салбаруудад:

- Амьдралд дасан зохицоход сэтгэцийн зөвлөгөө өгөх
- Боловсролын зөвлөгөө
- Мэргэжлийн зөвлөгөө
- Хувийн бие даах зөвлөгөө

Хараа алдагдлын хариу урвал

- Дасан зохицолтын үе шатуудыг таамаглах боломжгүй
- Хувь хүний хараа алдагдалд үзүүлэх хариу урвалд хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлдөг:
- Хараа алдагдлын зэрэг
 - Өвчин үүссэн хурд
 - Өвчний тавилан
 - Өвчин эхэлсэн нас
 - Тухайн хүний сохролын талаархи хуучин үзэл баримтлал
 - Бусад эрүүл мэндийн хүчин зүйлс
 - Нийгмийн орчин болон амьдралын хэв маяг
 - Хувь хүний зан чанар
 - Өмнө нь бусад зовлонг даван туулж байсан чадвар чадамж

Хараа алдагдалд дасан зохицох үйл явцын үе шатууд

Гэнэтийн цочрол ба Үл итгэл

- Бүгдийг хаях хугацаа байж болно
- Хамгаалах сэтгэл хөдлөлийн мэдээгүйжүүлгийн үе нь маш хүнд зэргийн стрессэнд өгч буй хариу урвал байж болно
- Энэ үе шат хэр удаан үргэлжлэхийг тааварлах боломжгүй
- Найз нөхөд, гэр бүл хажууд нь байж асран халамжилж болох ч өвөрмөц үйлдэл эсвэл үг хэлэх шаардлагагүй
- Харааг сэргээж чадна хэмээн худал итгэл өгөх нь тийм ч сайн санаа биш

Хараа алдагдалд дасан зохицох үйл явцын үе шатууд

Уур хилэн

- Хувь хүн сэтгэл хөдлөлөө маш хурц сөрөг хандлагаар илэрхийлнэ
- Асран халамжилж байгаа хүн болон гэр бүлийнхэн нь сэтгэлээр унаж, цөхөрнө
- Эмнэлгийн ажилчид, асран халамжлагч, гэр бүл болон найзууд нь үйлчлүүлэгчийн уур уцаарын бай болж болно

Хараа алдагдалд дасан зохицох үйл явцын үе шатууд

Үгүйсгэл

- Нөхцөл байдлын шууд үгүйсгэл эсвэл харааны хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзана
- Энэ үед үйлчлүүлэгч хараагүйчүүдийн агентлагт хандахаас татгалзаж болно

Хараа алдагдалд дасан зохицох үйл явцын үе шатууд

Сэтгэл гутрал:

- Бусдаас ялгаатай болсон мэдрэмж, хяналтаа алдаж буй мэт мэдрэмж нь энэ хариу урвалын үндэс суурь болж болно
- Үйлчлүүлэгч бусдаас туслаарлагдмал байхыг илүүд үзнэ

Хараа алдагдалд дасан зохицох үйл явцын үе шатууд

Ухаарал

- Үйлчлүүлэгч сэтгэл гутралын байдлаас гарч, харааны өөрчлөгдөлтийн хувиршгүй нөлөөг ухаарч эхэлнэ
- Өөрт үлдсэн сайн тал болон чадамжийг ойлгон үүссэн нөхцөлийн таагүй үнэнг хүлээн зөвшөөрөх байдлыг дасан зохицол хэмээн тодорхойлох нь илүү бодит байдалтай нийцнэ

Хараа алдагдалд дасан зохицох үйл явцын үе шатууд

Хүлээн зөвшөөрөл

- Хараа алдагдал эцсийн бөгөөд эргэшгүй бодит үнэн гэдгийг үйлчлүүлэгч ухаарна

Хараа алдагдалд дасан зохицох үйл явцын үе шатууд

Хүлээн зөвшөөрөлд хүргэхэд нөлөөлж болох хүчин зүйлс:

- Ижил байдлаас гарсан бусад хүмүүстэй уулзах
- Өмнө нь учирсан зовлонт бэрхшээлүүдийн үед тусалж байсан арга замуудыг олж нээх
- Хараа алдсандаа гашуудах хугацаа
- Гэр бүл, найз нөхдийн дэмжлэг
- Илүү хариуцлага үүрэхдээ бэлэн болох хүртлээ өдөр тутмын үйл ажиллагаандаа дэмжлэг авах
- Боломжит нийгмийн тусламж дэмжлэгийн талаар мэдээлэл цуглуулах

Хараа алдагдалд дасан зохицох үйл явцын үе шатууд

- Хувь хүн дээрх үе шат бүрээр дамжихгүй байж болно
 - Тэр дундаа хүлээн зөвшөөрөх болон дасан зохицох үе шатуудаар дамжихгүй байж болно

Хараа алдагдалд дасан зохицох үйл явцын үе шатууд

- Муу дасан зохицлыг илтгэх зарим жишээнүүд
 - Эдгэнэ гэсэн байнгын, үндэс суурьгүй итгэл
 - Хамааралт байдлыг шаардлагагүй нөхцөлд хэт ихээр гаргах
 - Хувь хүний үнэгүйдэл
 - Нийгмээс тусгаарлалт
 - Сэдэлт идэвхижүүлэлтийн дутагдал
 - Урт хугацааны сэтгэл гутрал
 - Үргэлжилсэн үгүйсгэлт
 - Сохор зан авирыг хэтрүүлэн гаргах

Харааны бэрхшээлтэй хүнтэй ажиллах зөвлөмж

- Тэдний хайр, хүлээн зөвшөөрлийн үндсэн шаардлага, өөрийн үнэ цэнэ, нэр төрийн яг ижил үнэлэгдэхүүнтэй
- Үүсч болох хязгаарлалтуудад эерэг байдал, ур чадвар болон үнэт зүйл, бодит төлвийг хадгалахыг чухалчлах хэрэгтэй
- Заавар зөвлөмж тодорхой, өвөрмөц байх хэрэгтэй
- Тэдний хийж дуусгасан ажлыг сайшаах байдлаар идэвхжүүлж, зөвхөн нэн шаардлагатай тохиолдолд туслах замаар аливаа ажлыг бие даан гүйцэтгэхийг дэмжих хэрэгтэй

Харааны бэрхшээлтэй хүнтэй ажиллах зөвлөмж

- Сохрол нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхгүй зан авирын хүндэтгэх шалтгаан болж болохгүй
- Харааны бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн гадаад байдал болон зан авир нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдөж байгаа эсэхээ тодорхойлохын тулд бусдын чин үнэнч санал бодолд найддаг
- Нийгэм, нийтийн зугаа цэнгэл болон үйл ажиллагаанд идэвхитэй оролцсоноор цаашид харилцаанд бүрэн уусан орох боломж нээгддэг

vision

for everyone...everywhere

brienholdenvision.org



Brien Holden Vision Institute